



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 112


Улаанбаатар хот

### Улаанбаатар хотын аварга шалгаруулах “Жүдо бөх”-ийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах “Жүдо бөх”-ийн тэмцээнийг 2018 оны 03 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Спортын төв ордонд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 3.532.000 /Гурван сая таван зуун гучин хоёр мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэг/-т үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500050

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны  
даргын 2018 оны... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах  
“Жүдо бөх”-ийн тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 26 x 20.000 төг = 520.000 төг 26 x 15.000 төг = 390.000 төг 52 x 10.000 төг = 520.000 төг	1.430.000
2.	Шүүгчдийн ажлын хөлс: 20 хүн x 2 өдөр x 20.000 төг	800.000
3.	Заал талбайн зардал	300.000
4.	Өргөмжлөл	100.000
5.	Медаль:	832.000
6.	Анонс	70.000
<b>Нийт дүн</b>		<b>3.532.000</b>

